



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

**Түрээслэгчийг сонгон шалгаруулах
комисс байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журмын 5.1 дүгээр зүйлийн 5.1.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрмийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 дүгээр давхарт байрлах 60 м² талбайг эмийн сангийн зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулж ажиллахыг комисс (С.Учрал)-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны .04. дугаар сарын .10... өдрийн
А/23 дугаар тушаалын хавсралт



КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	С.Учрал	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Хуулийн мэргэжилтэн
Гишүүд:	С.Онон	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Санхүү, бүртгэлийн ажилтан
	Б.Нарантуяа	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Үйл ажиллагаа, төлөвлөлт хариуцсан албаны дарга
	Д.Оюунчимэг	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Сувилахуйн албаны дарга
	Т.Нямсүрэн	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Эм, бараа материалын нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга:	Б.Номинтуул	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүний нөөцийн тасгийн эрхлэгч